
ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1 Газрын гадарга, усан сүлжээ, цаг уур	6
2.2 Ургамал, амьтны ертөнц.....	7
2.3 Бүс нутгийн хөгжил, зам харилцаа, дэд бүтэц	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1 Агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	9
3.2 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл.....	9
3.3 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл.....	9
3.4 Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
3.5 Хог хаягдлын нөлөөлөл.....	10
4. 2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	101
4.1 Нөхөн сэргээлт.....	11
4.2 Техникийн нөхөн сэргээлт.....	12
4.3 Биологийн нөхөн сэргээлт.....	13
4.4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	16
4.5 Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс.....	16
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
5.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	18
5.2 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	19

5.3 ГАЗАР, ХӨРСНИЙ ЭЛЭГДЭЛ, ЭВДРЭЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭ.....	20
5.4 УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	22
5.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ.....	23
5.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24
5.7 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
<u>5.8 БАЙГАЛ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ.....</u>	<u>235</u>
5.9 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ.....	26
<u>5. Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....</u>	<u>27</u>
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	29
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..	30
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	31
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	32
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	33
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	34
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	35


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-001498 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол.....	6
Хүснэгт 2. Нөхөн сэргээлтийн ажлын тооцоо	13
Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах ажилд шаардагдах зардал.....	15
Хүснэгт 4. 2021 онд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажил.....	18
Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил.....	19
Хүснэгт 6. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд .	18
Хүснэгт 7. Тэрбум мод тарих хөтөлбөр	21
Хүснэгт 8. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд	19
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх ажил	23
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	24
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	25
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа	23
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлын нэгтгэл.....	26

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Шарын голын нүүрсний орд газар нь Улаанбаатар хотоос хойш 215 км, Эрдэнэт хотоос зүүн тийш 175 км, Дархан хотоос зүүн урагш 45 км зайтай Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт оршдог.

“Шарын гол” хувьцаат компаний эзэмшилд байгаа Шарын голын нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь монгол орны нутгийн төв дунд улс төр, эдийн засгийн, соёл шинжлэх ухааны олон улсын өндөр ач холбогдол бүхий нийслэл Улаанбаатар, Дархан хот болон ОХУ - Монгол Улс - БНХАУ-ыг холбосон төмөр зам, авто хөсгийн замын дэргэд байдгаараа чухал ач холбогдолтой.



Зураг 1. Ордын байршлын тойм зураг

Энэ ордыг олборлож эхэлснээс хойш 50 шахам жил болж төвийн районы нийслэл Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг эдийн засгийн томоохон хот суурин, аймаг, орон нутгийн энергийн түлшний хэрэгцээг хангаж байдаг юм.

MV-001498 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	106° 27' 26.2"	49° 15' 31.91"	56	106° 28' 23.17"	49° 13' 28.21"
2	106° 27' 26.2"	49° 15' 14.91"	57	106° 28' 19.81"	49° 13' 30.79"
3	106° 28' 12.21"	49° 15' 14.91"	58	106° 28' 21.91"	49° 13' 33.35"
4	106° 28' 12.21"	49° 14' 42.91"	59	106° 28' 12.58"	49° 13' 36.88"
5	106° 28' 37.21"	49° 14' 42.91"	60	106° 28' 11.15"	49° 13' 36.88"
6	106° 28' 37.21"	49° 14' 15.71"	61	106° 28' 11.15"	49° 13' 37.44"
7	106° 28' 17.82"	49° 14' 15.94"	62	106° 28' 7.14"	49° 13' 38.96"
8	106° 28' 17.71"	49° 14' 11.91"	63	106° 28' 3.58"	49° 13' 40.88"
9	106° 28' 11.2"	49° 14' 11.91"	64	106° 27' 59.74"	49° 13' 40.95"
10	106° 28' 11.2"	49° 13' 36.92"	65	106° 27' 49.76"	49° 13' 43.74"
11	106° 28' 34.2"	49° 13' 36.92"	66	106° 27' 56.93"	49° 13' 49.45"
12	106° 28' 34.2"	49° 13' 5.91"	67	106° 28' 0.71"	49° 13' 50.45"
13	106° 27' 20.2"	49° 13' 5.91"	68	106° 28' 1.16"	49° 13' 51.32"
14	106° 27' 20.2"	49° 12' 34.92"	69	106° 28' 3.4"	49° 13' 51.71"
15	106° 26' 52.31"	49° 12' 34.92"	70	106° 28' 5.84"	49° 13' 52.36"
16	106° 26' 44.67"	49° 12' 36.97"	71	106° 28' 6.65"	49° 13' 53.03"
17	106° 26' 43.41"	49° 12' 36.98"	72	106° 28' 8.65"	49° 13' 55.77"
18	106° 26' 35.56"	49° 12' 34.92"	73	106° 28' 8.61"	49° 13' 58.34"
19	106° 26' 31.2"	49° 12' 34.92"	74	106° 28' 8.85"	49° 13' 59.46"
20	106° 26' 31.2"	49° 13' 6.92"	75	106° 28' 11.16"	49° 14' 0.58"
21	106° 25' 41.2"	49° 13' 6.92"	76	106° 28' 11.16"	49° 14' 4.58"
22	106° 25' 41.2"	49° 12' 34.92"	77	106° 28' 7.78"	49° 14' 4.64"
23	106° 25' 3.2"	49° 12' 34.92"	78	106° 28' 3.77"	49° 14' 1.11"
24	106° 25' 3.2"	49° 13' 8.92"	79	106° 28' 1.11"	49° 13' 55.48"
25	106° 23' 13.2"	49° 13' 8.92"	80	106° 27' 54.66"	49° 13' 53.26"
26	106° 23' 13.21"	49° 13' 41.92"	81	106° 27' 47.39"	49° 13' 47.27"
27	106° 23' 38.21"	49° 13' 41.92"	82	106° 27' 39.26"	49° 13' 45.99"
28	106° 23' 38.21"	49° 14' 13.91"	83	106° 27' 34.43"	49° 13' 43.19"
29	106° 26' 2.21"	49° 14' 13.91"	84	106° 27' 29.28"	49° 13' 46.38"
30	106° 26' 2.21"	49° 14' 4.91"	85	106° 27' 19.51"	49° 13' 44.82"
31	106° 26' 11.2"	49° 14' 4.91"	86	106° 27' 16.89"	49° 13' 45.92"
32	106° 26' 11.2"	49° 13' 54.91"	87	106° 27' 10.2"	49° 13' 45.32"
33	106° 26' 29.86"	49° 13' 54.91"	88	106° 27' 4.78"	49° 13' 42.96"
34	106° 26' 29.85"	49° 13' 54.82"	89	106° 27' 2.99"	49° 13' 44.22"
35	106° 26' 29.67"	49° 13' 54.45"	90	106° 26' 58.86"	49° 13' 43.4"
36	106° 26' 31.35"	49° 13' 50.12"	91	106° 26' 50.13"	49° 13' 44.66"
37	106° 26' 32.54"	49° 13' 46.97"	92	106° 26' 51.13"	49° 13' 47.09"
38	106° 26' 36.61"	49° 13' 43.44"	93	106° 26' 42.93"	49° 13' 49.41"
39	106° 26' 43.41"	49° 13' 43.36"	94	106° 26' 38.41"	49° 13' 47.94"
40	106° 26' 45.93"	49° 13' 41.37"	95	106° 26' 37.15"	49° 13' 49.51"
41	106° 26' 57.38"	49° 13' 39.41"	96	106° 26' 40.8"	49° 13' 51.98"
42	106° 27' 6.75"	49° 13' 39.24"	97	106° 26' 35.44"	49° 13' 58.79"
43	106° 27' 12.71"	49° 13' 40.84"	98	106° 26' 34.21"	49° 13' 59.3"
44	106° 27' 29.33"	49° 13' 41.05"	99	106° 26' 34.21"	49° 14' 13.91"
45	106° 27' 34.47"	49° 13' 38.67"	100	106° 26' 28.2"	49° 14' 13.91"
46	106° 27' 37.1"	49° 13' 38.72"	101	106° 26' 28.2"	49° 14' 44.92"
47	106° 27' 41.82"	49° 13' 42.47"	102	106° 26' 36.21"	49° 14' 44.92"
48	106° 27' 49.96"	49° 13' 39.28"	103	106° 26' 36.21"	49° 15' 6.92"

49	106° 28' 0.95"	49° 13' 36.61"	104	106° 26' 47.21"	49° 15' 6.92"
50	106° 28' 4.07"	49° 13' 34.73"	105	106° 26' 47.21"	49° 15' 16.91"
51	106° 28' 8.51"	49° 13' 34.06"	106	106° 27' 0.2"	49° 15' 16.91"
52	106° 28' 19.5"	49° 13' 23.37"	107	106° 27' 0.2"	49° 15' 28.52"
53	106° 28' 34.08"	49° 13' 23.81"	108	106° 27' 2.22"	49° 15' 28.51"
54	106° 28' 34.08"	49° 13' 27.6"	109	106° 27' 6.4"	49° 15' 31.08"
55	106° 28' 31.24"	49° 13' 28.14"	110	106° 27' 6.4"	49° 15' 31.91"

MV-001498 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 1826.18 га хэмжээтэй талбайд /одоогоор 1767.19 га болсон/ ашигт малтмал ашиглахаар 2009 оны 7-р сарын 03-д “Шарын гол” ХХК 30 жилийн хугацаатайгаар авсан байна. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлуудыг доорх хүснэгтэнд үзүүлэв.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Газрын гадарга, усан сүлжээ, цаг уур

Шарын голын нүүрсний орд газар нь Орхон-Сэлэнгийн сав газрын зүүн өмнөд хэсэгт Хан Хэнтийн нурууны салбар уулсын зах хэсэгт 800-1000 метр хүртэл өргөгдсөн ойт хээрийн бүсэд оршино. Ордын орчны уур амьсгал нь хахир хүйтэн өвөл, хавартай, чийглэгдүү сэрүүн зун намартай эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Хүйтэн ба дулааны улирал: Салхины ноёлох чиглэлийг авч үзвэл өвлийн саруудад өмнө чиглэлүүдийн, хаврын саруудад баруун хойноос зүүн хойд, зуны саруудад баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн, намрын улиралд баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн давтагдал 9.7-29 % ноёлж байдаг ба өвөл намар зуны саруудад 2.5-5.0 м/с, хаврын сард 4.3-6.4 м/с байдаг.

Нарны гийгүүлэл уурхайн орчимд жилдээ 2585 цаг байдаг ч түүний хоног сарын хуваарилалт нь нарны өндөр, улирал, үүлшил зэргээс хамаарна. Зуны саруудад 240-270 цаг, өвлийн саруудад 140-190 цагийн гийгүүлэлттэй байдаг. Нүүрсний орд газарт дулаан хүйтний нөхцөл болох жилийн дундаж агаарын температур -0.9°C байдаг бөгөөд хамгийн дулаан 7 дугаар сард 18.8°C , хамгийн хүйтэн 1 дүгээр сард -25°C . Үнэмлэхүй их халуун 39.4°C , үнэмлэхүй хамгийн их хүйтэн -43°C хүрч байжээ. Энэ бүс нутагт жилдээ 260-300 мм хур тунадас орж байдгийн 90 % гаруй нь зөвхөн дулааны улиралд унана. Агаарын харьцангуй чийгшил нь температурын эсрэг явцтай, жилдээ 66% байдаг нь уг район нь чийглэгдүү гэдгийг харуулж байна. Харьцангуй чийг өвлийн саруудад хамгийн их 72-78%, дараагийн их хэмжээ зуны саруудад 56-66%, хавар 39.8-49% байдаг.

Шарын голын нутаг дэвсгэрт хөрсний хөлдөлт гэсэлт нь тухайн жилийн цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалдаг. Хөрсний хөлдөлт дунджаар 10 дугаар сарын 15-наас эхлэн хөрсний гүн рүү хөлдөлт нэвчиж дараа жилийн 5 дугаар сарын 20 хүртэл нийтдээ хөрсний гадарга хавьд 207 хоног хөлдөлттэй байдаг. Хөрсний гэсэлт дунджаар 4 дүгээр сарын 10-наас 6 дугаар сарын 15-ны хооронд явагдана. Хөрсний хөлдөлтийн гүн нь хөрсний чийг, механик бүрэлдэхүүнээс хамаарч шавар шавранцарт 2.7 м, элсэнцэрт 2.9 м, элсэнд 3.4 м, хайрга, хайрганцар хөрсөнд 3.8 м тус тус байх боловч уурхайд үүнээс бага байдаг.

Ус зүй: Нүүрсний уурхайн дэргэдүүр Шарын гол урсдаг бөгөөд энд Шаазгайт, Буянт, Хавчуугийн жижиг голууд цутгадаг. Эдгээр голууд нь тухайн орчны экологи, эдийн засгийн чухал нөлөөтэй. Нүүрсний уурхайн үйл ажиллагаатай холбогдон Шарын голын үндсэн гольдролыг 2 км орчим газар шилжүүлэн урсгасан байна. Шарын гол нь Хэнтийн нурууны салбар уулсаас эх авч 2930 км² талбайгаас усжин 200 орчим км урсаж Орхон голд цутгана. Голын өргөн нь өргөн хэсэгтээ 200-25 м, гүн нь 0.20 - 0.80 м байдаг. Шарын голын тэжээгдлийн эх үүсвэрийн 20 гаруй хувийг хөрсний ус, үлдсэн хувийг хур тундасны ус эзлэх тул усны горимын хэв шинж хаврын шар ус, зуны хур борооны үерийн горимтой голд хамааруулдаг.

Шарын голын усны химийн найрлагын голлох эх сурвалж нь голын сав газрын уулын чулуулаг хөрс юм. Шарын голын ус нь химийн найрлагын хувьд гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн дунд зэргийн эрдэсжилт хатуулагтай усанд хамрагдана.

2.2 Ургамал, амьтны ертөнц

Шарын голын нүүрсний уурхайн эдэлбэр нь уулт - ойт хээрийн бүсэд Хавчуу, Шаазгайт, Шарын голын бэлчир хавийг хамран бэсрэг уулсын хоорондох хөндийд 900-1000 м хүртэлх үнэмлэхүй өндөрт оршино. Энэ орчмын уулс, ухаа гүвээ, талархаг дэнж газраар хар хүрэн хөрс, голын татам, хотос нам газраар нугын ба нугат - намгийн хөрс, нугархаг газрын захаар нугат - хүрэн хөрс, нарс-хус, шинэс-хусан холимог ойд ойн бараан хөрс, түүний эргэн тойронд хар шороон хөрстэй байна.

Амьтан, ургамал: Шарын голын нүүрсний орд газар нь экологи газар зүйн хувьд ойт, уул хээрийн бүслүүр гэж нэрлэж болох өвөрмөц ландшафтыг үүсгэжээ. Уулын энгэр хажуугийн болон ойт хээрийн бүс ээлжлэн солигдож байдаг. Ой мод нь уулын арын хажуу дагуу ургах ба хээрийн бүс нь уулын өвөр, энгэр бэл, уулс хоорондын хөндий хоолойгоор ажиглагдаж байдаг. Уг нутаг нь Монгол орны хангай бүсийн шинжийг илэрхийлсэн, ургалт харьцангуй шигүү 1м² талбайд ургасан ургамлын тоо 60-100, өндөр нь 4-14 см хооронд хэлбэлзэж байна.

Энд Хангайн хэв шинжийн нам уулсын нийлмэл цэцэгтэн, үетэн, буурцагтнаас гадна холтсон цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтэн гэх зэрэг ерөнхийдөө түгээмэл байдаг овгууд нэлээд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Шарын голын районы амьтны аймаг баян, төрөл зүйл олонтой төвийн болон ойт хээрийн бүсийн хөхтний бүлгэмдэл, олон зүйлийн туурайтан, махан идэштэн оршдог нутаг юм. Төрөл бүрийн олон наст ургамал, үетнээс шивээт хялгана, хазаар өвс, хиаг, ерхөг, ботууль түүнчлэн агь, бударгана, цахилдаг зэрэг ургамал зонхилж ургана.

2.3 Бүс нутгийн хөгжил, зам харилцаа, дэд бүтэц

Монгол Зөвлөлтийн хайгуулын баг 1958-1960 онд Шарын голын нүүрсний орд газрыг нээж илрүүлэн ашиглалтын нөөцийг тогтоосноор 1961 оны 10-р сарын 17-нд уурхайн тосгоны анхны суурийг тавьж, улмаар 1962 онд Шарын гол хот байгуулагдсан.

Шарын гол сум нь Хэнтийн нурууны салбар Дархан-Уулын өвөрт далайн түвшнээс дээш 920 м өндөрт оршдог, 16060 га нутаг дэвсгэртэй, 7.8 мянган хүн амтай, 2.1 мянган өрхтэй, 57.0 мянган толгой мал бүхий 200 гаруй өрх хөдөө амьдардаг. Шарын гол сум зүүн болон зүүн урд талаараа Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум, бусад талаараа Дархан-Уул аймгийн Хонгор сумтай хиллэдэг. Улаанбаатар хотоос 210 км, Дархан-Уул аймгаас 75 км авто замаар холбогдсон, Дархан-Шарын голыг холбосон станц, 109.5 км урттай төмөр зам, 1900 тн дизель түлш, бензин хадгалах нефтийн 4 агуулах бүхий орчин үеийн холбоо мэдээллийн сүлжээнд холбогдсон дэд бүтэц хөгжсөн томоохон суурин юм.

Тус суманд нүүрсний томоохон уурхайнуудын нэг Шарын гол ХК, Дулаан Шарын гол ХК, алт олборлолтын уурхайнууд, худалдаа нийтийн хоолны чиглэлээр үйлчилгээ явуулдаг 130 гаруй аж ахуйн нэгж, байгууллагууд ажиллаж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дотоод овоолгын зарим хэсэгт бохир хөрс болон чулуулгийн өөрийн шаталт явагдаж байдаг хүйтний улиралд утааны хэмжээ нэмэгддэг. “Энверонментал комплайнс” компаниар хийлгэсэн “Байгаль орчны аудит” –ын дүгнэлт, зөвлөмжийн дагуу агаарын бохирдлыг бууруулах ажлыг 2021 оны бизнес төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллана.

3.1 Агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хуурайшилт ихтэй улиралд зам талбайг тогтмол услан зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулж, олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж байна. Уурхайн замаар зорчих хурдны хязгаарыг тогтоож, зөвхөн уурхайд мөрдөгддөг замын

хөдөлгөөний нэмэлт дүрмүүдийг баримтлан ажиллах ба 2021 онд 3 цэгээс улирал болгон агаар, тоосны шинжилгээ хийлгэж ажиллахаар төлөвлөж байна.

Ил уурхайн уурхайлалтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг тэсэлгээ, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг боирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна.

3.2 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулахаас гадна хөрсний хүнд метал, хөрсний био ялмагын шинжилгээ өгч ажиллана. Мөн 5 цэгээс цацрагийн шинжилгээ өгч Дархан - Уул аймгийн Мэргэжлийн хяналтын цацрагийн байцаагчаар дүгнэлт гаргуулан ажиллах төлөвлөгөөтэй байна.

3.3 Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Манай уурхай жилд 657.000 мян м³ ус шавхан зайлуулдаг. Шавхан зайлуулж буй уснаас алтны шороонд ордод 2.8 км шугам татаж шавхан зайлуулж буй усны 40% -ийг эргүүлэн ашиглаж байна. Усны цогц бодлогын дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, холбогдох дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Ил уурхайгаас гарах шүүрлийн усыг тоос дарах, зам услах, ногоон байгууламж, мод услах зорилгоор ашигладаг ба усны төлбөр тооцоог цаг тухайд нь төлөх, тайлагнах, ил уурхайн шүүрлийн усны дүгнэлтийг “Усны Газраар гаргуулахаар холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.

3.4 Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ил уурхайн уурхайлалтын явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг тэсэлгээний ажил ихээр хийгдэж, үйл ажиллагаанаас үүссэн тоос шорооны нөлөөгөөр ургамлан нөмрөг устаж, тухайн газарт нутагшсан амьтад амьдрах орчноо алдана. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад өртөх зэрэг нөлөөллүүд үүснэ.

Өнгөн хөрсийг хуулах үед тухайн газрын ургамлан нөмрөг, шавьж, жижиг мэрэгчид зэрэг амьтад үгүй болсон байна. Ил уурхайд явцын нөхөн сэргээлтээс илүү уурхайн эцсийн

буюу хаалтын нөхөн сэргээлт илүү оновчтой байдаг. Хуулж авсан өнгөн хөрсийг стандартын дагуу овоолго хийн хэлбэржүүлэн хадгалж, явцын нөхөн сэргээлтэнд хэрэглэж байна.

3.5 Хог хаягдлын нөлөөлөл

Аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдлыг салхинд хийсгэхгүй байх зорилгоор сумын хогийн цэгт улирал болгон бульдозер гаргаж хог хаягдлыг булшлах, сум орон нутагтайгаа хамтран ажиллах, Шарын гол сумын ЗДТГазартай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллаж байна.

2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1 Нөхөн сэргээлт

Төслийн үйл ажиллагааны явцад эвдрэл, элэгдэлд орсон хөрсийг дахин сэргээхийн тулд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг зайлшгүй хийх техникийн шаардлага тавигддаг. Үүнд:

1. Ашиглалт явагдаж дууссан малталтын хана, мөргөцөг, гадаад овоолгын хажуу зэргийг гулсалт, суулт, эвдрэлээс хамгаалах, нөхөн сэргээх
2. Олборлолт-малталтанд орох, овоолгод дарагдах газрын шимт өнгөн хөрсийг тусад нь хадгалах буюу нөхөн сэргээлтэнд шууд ашиглах. Мөн овоолсон шимт өнгөн хөрсийг салхинд хийсэх, үерийн усанд урсахаас хамгаалах арга хэмжээ авна.
3. Уулын ажлын жил бүрийн төлөвлөгөөнд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцоолон төсөвлөх
4. Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажилд одоо мөрдөж байгаа стандартын шаардлага, техникийн горим, журмыг баримтлана. Жишээлбэл: Ашигт малтмалыг эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, газар шорооны ажлын үед шимт хөрсийг хуулах, эвдэрсэн газарт хучилт хийх хөрс, эвдэрсэн газрын хажуугийн налуу г.м.
5. Хучаас хөрс, овоолгын догол түүний хажууг инженер геологийн төрөл бүрийн процессоос (гулсалт, суулт, эвдрэл) хамгаалах, овоолгын өндрийг 10 м-ээс ихгүй байлгаж ажиллана.
6. Инженер геологийн төрөл бүрийн процесс (гулсалт, суулт, нуралт, эвдрэл, хэв гажилт) малталтын мөргөцөг, хана, овоолгод үүсч байгаа эсэх тэдгээрт байнгын ажиглалт хийх, урьдчилан сэргийлэх, хамгаалах

7. Уурхайн хажуугийн налуугийн ерөнхий өнцгийг 45^0 -аас ихгүй, хамгаалалтын тавцангийн өргөнийг 20 м-ээс багагүй байлгах
8. Нуралт, суулт, гулсалт үүссэн хэсгийг тогтоож, хамгаалалтын бүс байгуулж, анхааруулах тэмдэг тавьж, ажил дууссаны дараа машин, тоног төхөөрөмжийг мөргөцгөөс холдуулан байршуулах, Овоолго болон уурхайн амсраар хамгаалалтын далан, шуудуу байгуулах

4.2 Техникийн нөхөн сэргээлт



Нөхөн сэргээсэн газар түүний хүрээлэн буй орчин нь олборлолтын дараа байгалийн тэнцвэрт байдлаа хадгалсан, унаган төрхөндөө ойртсон, хүн, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байлгах. Үржил шимт хөрсний овоолгын өндөр 3 м-ээс ихгүй, түүнийг олон дахин зөөж шилжүүлэхгүй байх нөхцлийг хангаж, бүрэн хэмжээгээр нөхөн сэргээлтэнд хэрэглэх боломжийг бүрдүүлнэ. Гадаад овоолго хийх талбайд үржил шим багатай, байгалийн нөлөөллөөр эвдэрсэн гуу, жалгатай газрыг сонгон орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгох.

Дотоод овоолгыг эхлээд чулуулгаар дүүргэж, дараа нь хучаас хөрсний үржил шим сайтай шороогоор дүүргэж тэгшилнэ.

Нөхөн сэргээлтийн объект нь:

- Ашигласан талбай руу шилжих ёсгүй экскаватор болон бульдозерын ажлын гадаад овоолго
 - Ус зайлуулах шуудуу
 - Талбайн гадаргад экскаватороор хөрс хуулахад үүссэн 45^0 налуутай хажуу хана ба ашиглалтын хана үүснэ.
 - Техникийн нөхөн сэргээлтийн үйл явцад дотоод, гадаад овоолгыг бульдозероор тэгшлэх ажил багтана. Тэгшилсний дараа шимт хөрсийг экскаватороор өөрөө буулгагч авто машинд ачиж, бэлтгэсэн талбайд буулгана. Дараа нь үржил шимт хөрсийг 20 - 25 см зузаантай үе болгон тарааж хэлбэржүүлнэ.
 - Экскаваторын овоолго конус ба трапец хэлбэрийн $30-35^0$ налуутай, 10-15 м өндөртэй бий болно. Эдгээр овоолго нь тодорхой хэмжээгээр эдгэрэх боломжтой нөхцлийг бүрдүүлэхийн тулд хур тунадасны нөлөөлөлд орохгүй хэмжээнд овоолгын налуугийн тогтвортой байдлыг хангана.
- Зүүн жигүүрийн хэсэгт 8,3 га талбай 720.000 м³ хөрсөөр, Баруун жигүүрийн хэсэгт 31.9 га талбай 8.0 сая м³ хөрсөөр техникийн нөхөн сэргээлт болон сул орон зайн дүүргэлт хийнэ.

Зураг 2. 2023 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зураг



Хүснэгт 2. Нөхөн сэргээлтийн ажлын тооцоо

Нөхөн сэргээлтийн ажлын төрөл	Ажлын хэмжээ	Талбайн хэмжээ	Зардал
Уурхайн зүүн, баруун хоёр хэсэгт нийт 40.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт буюу сул орон зайн дүүргэлт хийнэ.	8,720.000 м ³ хөрс	40.2 га	45.000.000 төг Техникийн нөхөн сэргээлт, Байгаль орчныг хамгаалах зардал

4.3 Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн гол зорилго бол техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг 0,05 м-ээс багагүй зузаан үржил шимт хөрсөөр хучиж ургамалжуулахад оршино. Ингэснээр сөрөг нөлөөлөлд өртсөн газрын хөрс, шороо салхинд хийсч агаар орчныг бохирдуулахаас хамгаалж, түүнийг байгалийн унаган төрхөнд нь ойртуулах, малын бэлчээр, хөдөө аж ахуй болон бусад зориулалтаар ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Байгалийн нөхөн сэргээх чадавхи нь эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд баримтлах нэг үндсэн нөхцөл болдог боловч дараах арга хэмжээнүүдийг зайлшгүй авах шаардлагатай.

1. Биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжөөр Тэрбум мод хөтөлбөр хүрээнд уурхайн өөрсдийн эзэмшлийн талбайд хавар намардаа 1000 гаруй мод тарих төлөвлөгөөтэй байна.
2. Эхний ээлжинд тухайн нутгийн шимт хөрс ялзмаг, хөрсний шимт чанарыг нэмэгдүүлэх, ургамлын ургах нөхцлийг сайжруулах зорилгоор бордоо хэрэглэх
3. Ашиглалтын эцсийн үе шатанд ашиглагдсан орон зай, ухааш болон овоолгын гадаргууг хэвгийжүүлэн тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2023 онд дүйцүүлэн хамгаалахаар Шарынгол сумын нутаг дэвсгэрт орших Цагаан хөтлийн давааны наад талд, мөн Хар ямаатын уулын бэл хуучинаар Засгийн газрын алтны уурхай ухаж овоолго үүсгэж үлдээсэн талбай юм. 2, 5 га талбайг Шарынгол сумын Засаг даргын тамгын газартай тохиролцон сонгон авлаа. Уг эвдэрсэн газрыг D-275 маркын бульдозер гарган түрж, 20 хэм орчим налуулан хэлбэржүүлж бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэнэ. Дүйцүүлэн хамгаалах ажил дууссаны дараа Шарынгол сумын Байгаль орчны комисст хүлэлгэж өгнө.

Дүйцүүлэн хамгаалах газрын солбицол:

1. 106 29 33,83 49 13 20,18
2. 106 29 33,86 49 13 22,57
3. 106 29 38,07 49 13 25.26
4. 106 29 43,44 49 13 24,47
5. 106 29 41,36 49 13 18,99
6. 106 29 33,83 49 13 20,18



Зураг 3. Цагаан давааны наад бэлд орших эвдэрсэн газрын зураг



Хар ямаат уулын бэл / Түрж тэгшилэх хэлбэришүүлэх/

Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах ажилд шаардагдах зардлын тооцоо

D-275 бульдозер ажиллахад гарах зардал болон бүтээл				
№	Зардлын төрөл	хэмжих нэгж /төг/	гарах бүтээл мян.м3	Ажлын зардлыг техникийн түрээсийн зардал буюу цалин хөлс, түлш г.м зардлууд орсон дүнгээр тооцов.
1	1 цаг ажиллахад	217.250	-	
2	1 ээлж ажиллахад гарах зардал	2.390.580	2.0	
3	7 хоног ажиллахад гарах зардал	28.690.200	48.0	
4	техникийг талбайд, хүргэх, авах г.м шууд бус зардалд	1.894.200		
	нийт зардал	15.292.200		

Талбайн хэмжээ 2.5 га, түрж тэгшлэх ажлын хэмжээ 24.0 мян.м3. Бульдозероор 1 ээлжинд 2мян.м3 шороо түрнэ. Тухайн ажлыг тасралтгүй 6 хоног хийж гүйцэтгэж дуусгана.

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Шарын гол ХК нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутаг дахь Шарын гол нэртэй газарт ашигт малтмал ашиглах лицензийн гэрчилгээг 1999 оны 04-р сарын 20-ны өдөр 1827.9 га талбайг, 1767.16 га талбайг 2018 оны 06-р сарын 08-ны өдрийн 424, 2014 оны 11 сарын 14 өдрийн а/246 тоот шийдвэрээр Газар ашиглах эрхийн гэрчилгээг авсан. Уг төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

4.5 Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс

Шарын голын нүүрсний уурхайн ойр орчимд нүүрс болон хөрсний мөрөгцгүүдээс түүх, соёлын дурсгалт зүйл, палентологийн зарим олдворууд илэрч байсан. Үүний нэг жишээ нь тус уурхайгаас 1960 -аад онд олдсон хирсний чулуужсан араг яс одоо Монголын байгалийн түүхийн музейд хадгалагдаж байна. Мөн шинэ газар хөндөж, хөрс хуулалт хийгээгүй болно. 2014 онд лицензийн талбайд уурхайн археологийн хайгуул судалгаа хийлгэсэн. Хайгуулаар олдсон эртний олдворуудыг хамгаалалтад авах талаар Археологийн хүрээлэнгээс зөвөлгөө мэдээлэл авч ажиллаж байна. Сүүлийн үед булш ухах хэсэг бүлэг хүмүүс бий болсон хашаажуулаж хамгаалалтад авахад ард иргэд болон булш ухагчид байгалын цогц байдлыг эвдэх асуудал үүснэ ийм учраас сумын байгаль орчны байцаагчтай хамтран үзлэг хийж ажиллана.

Мөн ТЭЗҮ-н нэмэлт тодотголын дагуу хөрс хуулалтын үйл ажиллагаа нэмэгдэх учраас газар шорооны ажлын явцад соёлын өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхайн үйл

ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн, олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “Шарын гол” ХК-ийн Нүүрсний уурхай төслийн 2023 оны уулын ажлын төлөвлөгөөг боловсруулав. Энэхүү төлөвлөгөөнд уг төслийн байгал орчныг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд төслийн одоогийн хүчин чадлын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хугацаанд уг төлөвлөгөө хүчин төгөлдөр байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Шарын гол” ХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгал орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх ёстой.

Тус компаниас байгаль хамгаалах, экологийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх талаар тухайн жилд явуулах үйл ажиллагааны далайц, цар хүрээний хэмжээ нь эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд гарах зардалтай тэнцэхүйц байх ёстой гэж үзэж болно.

5.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 4. 2023 онд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажил

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Тайлбар
1	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байна.	Засварын хэсэг	500 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байна.
2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол усалж байна.		Үйл ажиллагааны зардалд
3	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уулын хэсэг, БО –ы мэргэжилтэн	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээний дүн
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.		Агаарын бохирдлын төлбөр 35.696.244 төг Үйл ажиллагааны зардалд
<i>Агаар бохирдуулсан татвар</i>		<i>Нийт 35.696.244 төг</i>	

5.2 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	2023 онд Ус ашиглах дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл гэрээ ававна	БО –ы мэргэжилтэн	835.913* 165.44 тооцоолол хийнэ.
2	Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийн шав тэмдэг сэргээх, мод тарина.	БО –ы мэргэжилтэн	ХЕГСГЗ, МХГ байгууллагуудын байцаагч мэргэжилтэн нарын хамт үзлэг шалгалт хийнэ.

3	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх		Хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал нь тусгагдсан бөгөөд шинжилгээний хариу хавсаргана.
---	---	--	--

5.3 ГАЗАР, ХӨРСНИЙ ЭЛЭГДЭЛ, ЭВДРЭЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 6. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Газар эзэмших гэрээг Шарын гол сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	БО – мэргэжилтэн	Эвдэрсэн газар, бэлчээр, барилга байгууламжын газруудыг ангилж гэрээ хийнэ .
2	40.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Уулын нэгдсэн хэсэг БО –ы мэргэжилтэн	Сул орон зайн дүүргэлт, трактор гаргаж бульдозер гаргаж түрж тэгшлэх.
3	Усны машин тогтмол ажилуулах, тоосжилтыг дарах	ХАБЭАХХ БО –ы мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардал
4	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	хэсэг нэгж БО –ы мэргэжилтэн	Болзошгүй ажлын зардал

Хүснэгт 7. Тэрбум мод тарих хөтөлбөрийн ажлын өртөг зардлын тооцоо

/Улиас, Агч, Бургас /

№	Зардал гарах ажлууд	Мөнгөн дүн	Тайлбар
1	Модны суулгац авах	1000 ш суулгац х 2000 =2.000.000 төг	Орон нутгийн мод үржүүлгийн газраас суулгацуудыг худалдан авах
2	Хашаа хайсны материал	2.000.000 төг	1 га газар хашаажуулах
	Нийт зардал	4.000.000 төг	

5.4 УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 8. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Олон салаа зам гаргахгүй байна	ҮЭДЗахирал	-
2	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	ХАБЭАХХ	Үйл ажиллагааны зардалд
3	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх.	ҮЭДЗ	Мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээ болон судалгааны ажлын тайлан байна. Зардал нь хяналт шинжилгээ, мониторингийн зардалд орсон.
4	Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа	БО –ы мэргэжилтэн	
5	Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархац		

5.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Уурхайн үйл ажиллагаанаас технологийн болон ахуйн хэрэгцээний хаягдал гарна.

Хог хаягдлын төрөл

А. ажлын байрууд, ажилчдын цайны газрын хог хаягдал

Б. төмрийн хаягдал

Ахуйн хог хаягдлыг зориулалтын хогийн бункерт хурааж, 7 хоногт 1 удаа өөрийн унаагаар ачиж зайлуулан сумын төвлөрсөн хогийн цэгт хаяна. Хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 400 м³. Механик засварын хэсэг болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд цуглуулж тээвэрлэн борлуулдаг ба бүрэн цэвэрлэж зайлуулсан. Хатуу хог хаягдлыг тээвэрлэх зардлыг үйл ажиллагааны зардалд тусган зарцуулдаг. Өдөрт 30 гаруй хүнд техник ажилладаг ба тосолгоо үйлчилгээ тогтмол хийгддэг. 1 техникт дунджаар 100 литр масло сольдог, жилдээ энэ нь 3 тн орчим хаягдал масло, тос хуримтлагддаг ба хаягдал тосны түр агуулахад цуглуулж эрх бүхий байгууллагатай гэрээ хийнэ борлуулах. Шарынгол сумын хот тохижуулах хэсэгтэй хог хаягдлын гэрээ байгуулан ажилладаг.

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх ажил

№	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Ахуйн болон хатуу хог хаягдлыг Шарын гол сумын төвлөрсөн хогийн цэгт хаяна.	Хэсэг нэгжүүд	Сумын засаг даргын захирамж
2	Хаягдал төмрийг хуримтлуулан, зарж борлуулах		Гэрээ байна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.
3	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож Шарын гол суманд улирал тутамд мэдээлж байна.	БО –ы мэргэжилтэн	Хог хаягдлын бүртгэл хийж, шатаах зуух хийж гүйцэтгэнэ.
5	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.		Зориултын агуулахад хадгалаж эрх байгуулагаруу борлуулах .
6	Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ.		Хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал нь тусгагдсан.

5.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний үзүүлэлтүүд

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Агаарт агаар бохирдуулагч нарийн болон том ширхэглэгт тоосонцор (Нийт тоос, PM ₁₀ , PM _{2.5})	карьер, засвар, гуанзны орчмоос	улирал тугам	4	200.000	800.000		Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага
2	Хөрсөнд (Pb), (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)	карьер, ШТС				800.000		Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх
3	Усанд физик хими, хүнд металлын үзүүлэлтүүд	гүний худаг, нуур				800.000		Усны чанар. Хортой хүнд металл тодорхойлох Рентген флуоресценцийн арга.
4	Цацраг	карьер	жилд	1	200.000	200.000		
	Нийт					2.600.000		

5.7 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхай нь үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 11. Байгал орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын ажлын хуваарь, зардлын задаргаа

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
			2022 он	
	1	2	3	4
1.	Байгал орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд	БО –ы мэргэжилтэн
2.	Байгал орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	500.000 төг х 2 удаа =1.000.000	6, 8 саруудад	БО –ы мэргэжилтэн, сургалтын төв
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Шарын гол сумын ЗДТГ-т хүргүүлэх	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	11 сард	“Шарын гол” ХК-ийн ТДЗахирал
		1.100.000		

**5.8 БАЙГАЛ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИХЭРЭГЖИЛТИЙГ
СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ**

Хүснэгт 12. Байгал орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, задаргаа

Хугацаа	Олон нийтэд тайлагнах, танилцуулах ажлын жагсаалт	Зохион байгуулах хүний албан тушаал
9-р сард	Уурхайн үйл ажиллагааг сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдэд газар дээр нь танилцуулна.	Байгал орчны мэргэжилтэн, компанийн удирдлага зохион байгуулна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.
11 сарын 1-нд багтаана	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан Дархан-Уул аймгийн байгал орчин аялал жуулчлалын газар хүргүүлнэ.	
10-р сараас 12-р сарын 1-нд багтаан	Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгч акт дүгнэлт гаргуулна.	

5.9 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Хүснэгт 13. Байгал орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлын нэгтгэл

№	2023 онд байгаль орчны чиглэлээр хийгдэх ажлын нэгдсэн төсөв	зардал (төг)	Тайлбар	
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	40.2 га техник нөхөн сэргээлт хийнэ.	Байгаль орчныг хамгаалах зардал	
2		Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15.284.400	Байгаль орчныг хамгаалах зардал
3		Түмэн мод тарих хөтөлбөр	4.000.000	Тэрбум модны хүрээнд
4		Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	200.000	Байгаль орчныг хамгаалах зардал
5		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	100.000	Байгаль орчныг хамгаалах зардал
6		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	1.000.000	Үйл ажиллагааны зардал
7		Захиргааны ойр орчмыг тохижуулах, мод зүлэг тарих	1.100.000	Байгаль орчныг хамгаалах зардал
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2.600.000	Байгаль орчныг хамгаалах зардал	
	Нийт зардал	69.384.000		

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, техникийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт, хөрс болон ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлын менежмент, түүх соёлын өвийг хамгаалах зэрэг арга хэмжээнд нийт төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэг жий н зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжү үлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Агаарын чанар	Тоосжилтыг багасгах, усалгаа хийх	Үйлдвэрлэлийн талбай буюу 10 га	га		10	50.000.000 үйл ажиллагааны зардалд	280 хоног	Байгал орчныг хамгаалах тухай хууль
2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Шүүрлийн усыг эргүүлэн ашиглах	Уурхайн гүний шүүрлийн усыг эргүүлэн ашиглах	м3		835.910	-	365	Усны тухай хууль Эргүүлэн ашигласан усны хэмжээгээр хөнгөлөлт авах
3.	Хөрсөн бүрхэвч	Техникүүдийг үндсэн замаар, нэг чигээр хөдөлгөөнд оролцуулах	Уурхайн ойр орчимд	га					Батлагдсан арга зүйн дагуу

4.	Газрын хэвлий	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу хийх	Шинээр олборлолтонд өртөх талбай						MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”, MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага”
5.	Уурхайн ашиглалт дууссаны дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн талбай						Батлагдсан аргачуул дагуу	
6.	Амьтны аймаг	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Уурхайн ойр орчимд						
	Нийт						50.000.000		

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө								
№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	Суларсан орон зайд дүүргэлт хийх	га	40.2	1.111.940	45.000.000	2023 онд	Нөхөн сэргээлтийн журам
2.	Биологийн нөхөн сэргээлт	Уурхайн ашиглалт дууссаны дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх	га	боломжтой талбайг шимт хөрсөөр хучилт хийнэ				
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх							
	Нийт			40.2		45.000.000		

7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө								
№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Цагаан давааны над талын эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт болон Хар ямаатын овоолгыг түрж тэгшлэх .	Техникийн нөхөн сэргээлт хийж, хэлбэршүүлэх	2.5 га талбай	-	Байгаль орчныг хамгаалах зардалд тусгагдсан	15.297.200	2023 онд	
	Нийт					15.297.200		

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө								
№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Уг төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно	0	0	0	0	0	0	

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө								
№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Илэрсэн эртний олдворуудыг улирал болгон хяналт тавиж ажиллана .	Олдвор илэрсэн талбайд	-	-	болзошгүй зардалд 200.000	тухайн нөхцөлд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.	Палеонтологийн дурсгал							
	Нийт					200.000		

10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө								
№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	8
1.	Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл	Эрх бүхий байгууллагаар барилга байгууламжийн Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэнэ.	Шарынгол ХК	1	10.000.00	10.000.000	1 жил тутам, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгохтой уялдуулан тухай бүр	Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам
2		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх	Шарынгол ХК	-	-	-		Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
	Нийт					10.000.000		Үйл жиллагааны зардал

13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2	3	4	5	6	7	
1	Ус, Агаар,хөрс, Цацраг шинжилгээ хийх	2.6 сая	2	5	8, 11	Б. Амангельд	
2	Техникийн нөхөн сэргээлт	45.0 сая	3,4	5,6	7,8,9	Б. Амангельд	
3	Дүйцүүлэн хамгаалах	15.2 сая		4, 5		Б. Амангельд Ээлжийн дарга нар	
4	Түмэн мод хөтөлбөр	4.0 сая	5		10	Б. Амангельд ТДЗахирал	
5	Түүх соёлын өвийг хамгаалах	0.2 сая	3	8	11	Б. Амангельд Сумын улсын байцаагч	
	Нийт	67.0 сая					

14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
4.	Сумын иргэд, Сумын ЗДТГ	Багийн хурал	Уурхайн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийсэн ажил	Улриалд 1 удаа	1.0 сая	Б. Амангельд	ЗДТГ Хурлын заал, Соёлын төв
	Нийт						